



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 31 өдөр

Дугаар

А/124

Мандалговь

“Од Эс Эс” ХХК-тай байгуулсан
гэрээний дүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 02 дугаарын сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.4, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн 27 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр оруулалтаар “Хулд суманд Эрэн хайх, аврах бүлгийг шинээр байгуулахад шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлэх” ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Од Эс Эс” ХХК-тай 100,595,070 (нэг зуун сая таван зуун ерэн таван мянга дал) төгрөгийн гэрээг 35,100,000 (гучин таван сая нэг зуун мянга) төгрөг болгон өөрчлөн байгуулсугай.

2.Батлагдсан техникийн үзүүлэлтийн дагуу “Хулд суманд Эрэн хайх, аврах бүлгийг шинээр байгуулахад шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нийлүүлэх” ажлыг чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Од Эс Эс” ХХК-ны захирал (Д.Чогсомжав)-д үүрэг болгосугай.

3.Дээрх байгууллагатай гэрээний дүнг өөрчлөн байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л.ДОРЖБАТ



4822150300